



Doula & kulturtolk нь шведэд амьдардаг жирэмсэн ээжийг хүүхдээ төрүүлэх үед нь эх хэлээр нь төрөлтийг нь удирдан, дэмжлэг үзүүлэх зорилготой.

Doula нь таньд болон танай гэр бүлд хүүхдээ төрүүлэх явцад тань төрөх эмнэлэгийн ажилчидтай чөлөөтэй харилцахад тань анхаарч, хэлний дэмжлэг давхар хүргэнэ.

Doula нь Швед улсын төрөх эмнэлэгийн ажиллах системийг мэддэг, төрөх тасагт ажиллахаар бэлтгэгдсэн мэргэшсэн хүмүүс болно. Doula нь ажиллаж байх хугацаандаа төрөх өрөөнд гарч болох гэнэтийн үйл явцыг тайлбарлаж, бүрэн ойлгоход тань тусална.

Doula нь таньтай холбогдсоноосоо хойш хүүхэд төрөх хугацаанаас нь өмнө 2 удаа уулзана. Уулзалтын зорилго нь та болон таны гэр бүлтэй танилцаж, Doula-н ажлын зорилго болон бусад холбогдох мэдээллийг өгөх болно. Тухайн уулзалтууд зөвхөн ажлын өдрүүдэд, ажлын цагаар явагдана.

Doula нь эм, эмчилгээний зөвөлгөө өгөх эрхгүй. Харин жирэмсэний явцад тань хүндрэл илэрсэн нөхцөлд зөв эмнэлэгийн байгууллагатай холбогдож, эмнэлгийн үйлчилгээ авхад тань тусалж болно.

Doula нь төрөх тасгийн ажилчидтай холбогдож таныг хэзээ төрөх тасагт ирж болох талаар ярилцаж, эмнэлэгийн ажилчдийн зааврыг таньд уламжилсанаар та төрөх эмнэлэг рүү явна.

Doula нь төрөх тасагт таны дараа очино. Хэрэв төрөх тасгийн ажилчид таны төрөлт бүрэн эхэлсэн, эсвэл төрөх явц удаан үргэлжлэх магадлалтай гэсэн дүгнэлт гаргасан тохиолдолд Doula нь таньтай хамт хүүхэд төрөх хүртэл ажиллана.

Хэрэв таныг хариуцаж ажиллах doula нь өвдөх, бусад шалтгаанаар ирэх боломжгүй болсон тохиолдолд түүний ээлжний Doula ирж таньд туслах боломжтой.

Таныг хүсвэл Doula нь амаржсаны дараах уулзалтыг төрсөний дараах тасагт /р/а ВВ/ эвсэл танай гэрт хийх боломжтой. Мөн нялх хүүхэдтэй гэр бүлүүдэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагаа ядуулдаг байгууллагуудын мэдээллийг өгч болно.

Анхаарах зүйлс:

- Таны төрөлт эхэлсэн анхны шинж тэмдэг илэрсэн үеэс л doula-даа утасдаж мэдээлэл өгөх. Таны өгсөн мэдээллийн дагуу Doula төрөх тасаг руу явах бэлтгэлээ хийх боломжтой болно.
- Doula-н үйлчилгээ нь үнэ төлбөргүй.
- Doula нар нь таны мэдээллийн нууцлалыг хадгалах үүрэгтэй!
- Төрөх хугацаа болсон нөхцөлд та болон танай гэр бүл өөрсдөө төрөх эмнэлэг рүү явна. Швед улсад хэвийн явагдах төрөлтөнд түргэн тусламжийн машинаар явдаггүй болно.
- Та болон танай гэр бүлийн хүнд ханиадны шинж тэмдэг илэрсэн тохиолдолд мэдэгдэх өгөх үүрэгтэй. Энэ мэдээлэл өгөх үүрэг doula нарт адилхан хамаарна.

